



Сурагчийн нэр:


Эхэлсэн: он сар өдөр



Бид ургамлын ашиг тусын талаар сайн мэддэг болсон. Харин эрхтнүүд нь ургамлын амьдралд өөр өөр үрэг гүйцэтгэдэг гэдгийг мэдэх үү? Ангидаа болон гэртээ тарьсан цэцэгт ургамлаа сайн ажиглаад эрхтэн тус бүрийн үүрэг юу болохыг эргэцүүлэн бодоорой.

Даалгавар

1 Ургамал ургахад хэрэгтэй хүчин зүйлсүүд юу вэ? Нэрлэн бичээрэй.



2 Ургамлын эрхтнүүдийг **ургал эрхтэн** ба **үржлийн эрхтэн** гэж ангилдаг. Дараах өгүүлбэрийг анхааралтай уншаад ургамлын эрхтнүүдийг ургал болон үржлийн аль нь болохыг ялган холбоорой.

Ургамлын амьдралын явцад өсөж, том болдог эрхтнүүдийг ургал эрхтэн гэнэ.

- үндэс
- цэцэг
- иш
- навч
- жимс
- үр

Ургамлыг үржиж олшроход нь дэмжлэг болдог эрхтнүүдийг үржлийн эрхтэн гэнэ.

3 Бид хоол хүнсэндээ олон төрлийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ хэрэглэдэг. Дараах ургамлын зургийг ажиглаад яг ямар эрхтнийг нь хүнсэндээ хэрэглэдэг болохыг нь нэрлээд **ургал** болон **үржлийн** эрхтний аль нь болохыг ялган холбоорой. Загварыг ашиглаарай.



4 QR кодыг уншуулан бичлэгийг үзээд ургамлын амьдралын эхний 10 хоногт гарч байгаа өөрчлөлтийг зурж, тайлбар бичээрэй.



Дууссан: сар өдөр

✓ Өөрийн үнэлгээ: 🗳️ 🗳️ 🗳️ 🗳️



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Чи гэр бүл, найзуудтайгаа хамтран ямар нэг ургамал тарьж үзсэн үү? Ургамлыг тарихын өмнө үрсэлгээгээ хэрхэн хийдэг вэ? Ажигласан уу? Хэрэв ажиглаж мэдээгүй бол дараах даалгавар, сорил туршилтыг хамтдаа хийцгээе.

Даалгавар

- 1 Үр соёолох үйл явцтай холбоотой өгүүлбэрийг зөв дараалалд оруулан 1,2,3 тоогоор дугаарлаарай.

- Нахиа гэрлийн зүг ургадаг.
- Жижиг үндэс нь газрын гүн рүү чиглэн ургадаг.
- Навч ургаж эхэлдэг.



- 2 Энхжин, Мөнхжин, Халиун гурав тус бүр 10 шошны үр соёолуулахаар туршилт хийжээ. Тэд адилхан шилэн тавганд хөвөн дэвсэж үрээ цацаад бүгд цонхны тавцан дээр тавьсан байна.

- Энхжин хөвөнгөө чийгтэй болтол усаар шүршсэний дараа үрээ цацаад хүнсний скочоор бүрхлээ.
- Мөнхжин хөвөнгөө мөн адил чийглэсний дараа үрээ цацаад хүнсний скочоор бүрхсэний дараа цоолж жижиг нүхнүүд гаргалаа.
- Халиун хөвөнгөө далд ортол ус хийгээд үрээ цацаад хүнсний скочоор бүрхлээ.

7 хоногийн дараа гурван найзын тарьсан үр хэрхэн соёолсон байхыг дүгнэн бичнэ үү.

- ❖ Энхжингийн тарьсан үр.....
Учир нь
- ❖ Мөнхжингийн тарьсан үр.....
Учир нь
- ❖ Халиуны тарьсан үр.....
Учир нь

- 3 Багш сурагчдад вандуйн үрийг соёолуулах туршилт хийх даалгавар өгчээ. Дараах QR кодыг уншуулан, бичлэгийг үзээд найздаа үрийг соёолуулахын тулд юуг анхаарах талаар зөвлөмж бичээрэй.

Линк: <https://youtu.be/WztV5c5Hlxk>

Зөвлөмж



.....

.....

.....

.....

.....


- 4 Үрээс үндэс гарахыг үр соёолох гэнэ. Үр соёолоход ямар хүчин зүйлүүд нөлөөлсөн бэ? Чи найздаа юу гэж зөвлөсөн бэ? Бичээрэй.

..... ,

Дууссан: сар өдөр



Өөрийн үнэлгээ:



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Ургамал болгон цэцэглэдэг үү? Цэцэгт ургамлын үржил хэрхэн явагддаг болохыг мэдэх үү? Цэцэглэдэггүй ургамлуудыг хэрхэн үржүүлж болох вэ? Эргэцүүлэн бодоод дараах дасгалыг ажиллаарай.

Даалгавар

1 Цэцэглэдэг болон цэцэглэдэггүй ургамал ямар ямар эрхтэнтэй байдаг вэ?

Цэцэгт ургамал

- үндэс
- иш
- навч
- цэцэг

Цэцэглэдэггүй ургамал

2 Цэцэглэдэггүй тасалгааны ургамлууд ихэвчлэн гоёмсог навчтай байдаг. Дараах тасалгааны ургамлын нэрийг нь мэдэх үү?. Аль нь навчаараа гоёдог ургамал вэ?



3 Дараах QR кодыг уншуулан бичлэгүүдийг үзээд үр бүхий жимс ургамлын ямар эрхтнээс үүсэж байгааг ажиглаарай. Цэцгийг яагаад үржлийн эрхтэн гэж нэрлэсэн болохын учрыг тайлбарлаж бичээрэй. Дараах өгүүлбэрийн утгыг гүйцээн бичээрэй.

Линк: <https://youtu.be/gRS80BqZ0dc>

Линк: <https://youtu.be/dx4kKQc09p8>



- Цэцэг нь бий болгодог.
- Жимс нь цэцэгнээс үүсдэг ба хамгаалдаг.

4 Цэцэгт ургамлын үр ямар замаар тархдаг вэ? Дараах зургийг хараад дүгнэн бичээрэй.



Дууссан: сар өдөр



Өөрийн үнэлгээ:





Сурагчийн нэр:


Эхэлсэн: он сар өдөр



Хүүхдүүд та нар хүнсэндээ хэрэглэсэн ургамлын үрийг үрслүүлж үзээрэй. Ургамлыг үрээр үрслүүлэх амархан шүү. Харин цэцэглэдэггүй ургамлыг үрээр үржүүлж болохгүй гэдгийг бид мэдлээ. Тэгвэл ямар аргаар үржүүлэх вэ? Дараах дасгал, даалгаврыг гүйцэтгэх явцдаа суралцаарай.

Даалгавар

- 1 Зурагт ургамлыг ишээр хэрхэн үржүүлж болох дарааллыг харуулсан байна. Доор бичсэн өгүүлбэрүүдэд тохирох зургийн үйл явдлын дугаарыг зөв сонгож тэмдэглээрэй.



- Цэцэггүй 2-5 навч, нахиа бүхий мөчир сонгон авна.
- Үндэслэсэн мөчрийг үржил шим сайтай хөрсөнд суулгана.
- Сонгосон мөчрийнхөө доод үзүүрийг ташуу огтолно.
- Хэд хоногийн дараа мөчир үндэслэж бие даан ургах чадвартай болно.
- Огтолсон мөчрөө усанд хийж үндэслүүлнэ.

- 2 “Мөнхрөө” тасалгааны ургамлыг хэрхэн үрслүүлж ургуулах вэ? QR кодыг уншуулан бичлэгийг үзээд, үрслүүлж ургуулахад анхаарах 2 гол зүйлийг найздаа зөвлөөрэй.

Линк: <https://youtu.be/ZtsGk6DyxGs>

Зөвлөмж




.....

.....

.....

.....

- 3 Дараах зураг тус бүрийг ажиглаад ямар ургал эрхтнээр нь үржүүлсэн болохыг нэрлээрэй.



.....

.....

.....

.....

Дууссан: сар өдөр



Өөрийн үнэлгээ:



Сурагчийн нэр:


Эхэлсэн: он сар өдөр




Амьд бие бүхэн өсөж хөгждөгтэй адил ургамал ургах, өсөж хөгжих, үр жимсээ боловсруулах хүртэл тодорхой цаг хугацаатай байдаг. Цэцэгт ургамлын амьдралын эргэлт гэж юуг хэлэх вэ?

Даалгавар


1 Зургаас шошийн ургалтын үе шатуудыг ажиглаад зөв дараалалд оруулан дугаарлана уу.



2 Цэцэгт ургамлын амьдралын үе шатыг дарааллын дагуу зөв нэрлээрэй.



3 Ургамлыг бид амьдралдаа хэрхэн ашигладаг вэ? Оюуны зураглалыг гүйцээн бичээрэй.



Дууссан: сар өдөр



Өөрийн үнэлгээ:

